



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/46

Хараат

Авто машингүй өдөр болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6"в", Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 6 сарын 1-ний өдрийг авто машингүй өдөр болгон зарласугай.

2.Автомашингүй өдрөөр сумын төвд өглөөний 10 цагаас 16 цагийн хооронд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хязгаарласугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг цагдаагийн хэсгийн төлөөлөгч М.Бат-Эрдэнэ, цагдаа Ч.Эрдэнэбулган нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БУДЖАВ

